

ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН

5 ХОРОМ



ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ ЭХЛЭХ үед

- Энэ эмийн нэр юу вэ, ямар үйлчилгээтэй вэ?
- Эмтэй холбоотой үүсч болох эрсдэл, гаж нөлөө юу вэ?



Эм УУХ үед

- Энэ эмийг хэдийд, мөн нэг удаад хэр хэмжээгээр уух вэ?
- Эмийн гаж нөлөө илэрвэл би яах ёстой вэ?



ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ НЭМЭГДЭХ үед

- Надад нэмэлтээр эм уух зайлашгүй шаардлага байгаа юу?
- Энэ эм нь миний ууж байгаа бусад эмтэй зохицох уу?



Хэрэглэж байгаа эмээ ХЯНАХ үед

- Эм тус бүрийг хэр удаан уух ёстой вэ?
- Уух шаардлагагүй болсон эмийг хэрэглэсээр байна уу?



ЭМИЙН ЭМЧИЛГЭЭГ ЗОГСООХ үед

- Эм тус бүрийг хэд хоног хэрэглээд зогсоох вэ?
- Эмтэй холбоотой гаж нөлөө илэрч, хэрэглээг зогсоовол би хэнд мэдэгдэх ёстой вэ?

Эмийн аюулгүй байдлын 5 хором гэдэг нь үйлчлүүлэгч эсвэл түүний асран хамгаалагчийн оролцоотойгоор эмийн хэрэглээтэй холбоотой хор хохирол үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн түлхүүр зарчмууд юм. Хором тус бүр 5 чухал асуултаас бүрдэнэ. Зарим асуултанд үйлчлүүлэгч бие даан хариулах боломжтой бол заримыг нь ойлгож, зөв хариулахын тулд эмнэлгийн мэргэжилтний тусламж шаардлагатай байдаг.

Үйлчлүүлэгчийн оролцоог тусгасан энэхүү зөвлөмжийг ДЭМБ-ын зүгээс "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн 3 дугаар Аяны нэг хэсэг болгон : Эмийн зохистой хэрэглээ сэдвийн хүрээнд " боловсруулан гаргасан байдаг.

Энэхүү зөвлөмж нь үйлчлүүлэгчийг өөрийн эрүүл мэндийг хамгаалахад илүү идэвхтэйгээр татан оролцуулах, эмийн талаарх мэдээлэлд тэдний анхаарлыг хандуулах, эмийн эмчилгээний талаар эмнэлгийн мэргэжилтнүүдтэй нээлттэй харилцах боломжоор хангахад чиглэсэн болно.

Тус зөвлөмжийг бүхий л төрлийн, мөн бүх түвшний эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүрээн дэх үйлчлүүлэгч, болон тэдний гэр бүл, асран хамгаалагч нарт зориулан боловсруулсан ба хэрэгжүүлэхэд эмнэлгийн мэргэжилтнүүдийн дэмжлэг шаардлагатай.

ДЭМБ/HIS/SDS/2019.3

© Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2019.
Зарим эрх хуулиар хамгаалагдсан.
CC BY-NC-SA 3.0 IGO лицензийн дагуу энэ материалыг авах боломжтой.



Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаас авна уу:
<https://www.who.int/patientsafety/>